



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2021.05.06 № 1а/2411
танай 2021.04.17 -ны № 17 -т

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилт, хавдрын үеийн тусламж, үйлчилгээ болон өндөрт өртөгтэй мэс заслыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа эсэх, эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлттэй олгож байгаа эмийн тухай, Ховд аймаг дахь БОЭТ-ийн өргөтгөл болон коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын явцын талаар эрхэм гишүүн Танаас ирүүлсэн асуулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь “стратегийн худалдан авагч” болж төрөөс төлбөрийг нь хариуцах зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах эрх зүйн орчин бүрдсэн.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад нэмэлт оруулж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор батлан 3 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна. Уг тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас төрийн өмчийн 392, хувийн хэвшлийн 2080, нийт 2472 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан эхний 4 сарын байдлаар 242,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг харгалзан олгожээ.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журам, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журмыг тус тус шинэчлэн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний

144215077

зөвлөлийн 04, 05 дугаар тогтоолоор тус тус баталсан. Өндөр өртөгтэй шинжилгээний жагсаалтыг шинэчлэн, өртгийн тооцооллыг хийж дуусгаад байна. Мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний үлгэрчилсэн загвар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх техникийн хорооны ажиллах журмуудыг бэлэн болгоод байна.

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг тогтоож өгсөн. Энэ дагуу бүх төрлийн хорт хавдрын эмийн болон мэс засал эмчилгээ, хавдрын дараах хими болон химийн бай эмчилгээ, хавдартай өвчтөний амбулаторийн хяналт, хими, туяаны өдрийн эмчилгээ, хавдрын дараах сэргээн засах эмчилгээг даатгалын сангаас бүрэн хариуцаж байна.

2021 оны эхний гурван сарын байдлаар хорт хавдрын 2527 тохиолдолд 1,5 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосноос хорт хавдартай 27 хүүхдийн эмчилгээнд 10,3 сая төгрөг зарцуулсан байна.

Хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу өндөр өртөгтэй мэс заслын хэрэгсэл, протез, ортопедийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцан төлдөг байсныг өөрчилж, мэс заслын тусламж, үйлчилгээний бүх зардлыг тухайн оношийн өртөгт шингээж, эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс төлөх хамтын төлбөрийн хэмжээг тодорхой болгож баталсан. Тухайлбал, эрхтэн шилжүүлэх мэс заслын нийт зардлыг 113,6 сая төгрөгөөр тогтоож, 75 хувь буюу 85,2 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас 25 хувь буюу 28,4 сая төгрөгийг иргэн төлөхөөр тогтоосон байна. Харин эрүүл мэндийн даатгалын хуульд заасан шимтгэлийг нь төрөөс хариуцан төлдөг иргэд хамтын төлбөр төлөхгүй бөгөөд тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь бүрэн хариуцахаар болсон.

2021 оны I улирлын байдлаар нийт 5034 иргэний мэс заслын тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас 6,8 тэрбум төгрөгийн зардлыг гаргаснаас хүүхдийн өндөр өртөгтэй мэс заслын зардалд нийт 108 хүүхдэд 192,1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүн амын зорилтот бүлэг болох ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэдэд санхүүгийн бодит дарамт учруулахгүйгээр эрүүл мэндийн шаардлагатай тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлснээр 2021 оны I

улирлын байдлаар зорилтот бүлгийн нийт 18221 иргэдэд 6,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан байна.

Гурав. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээ”-г шинэчлэн баталсан.

Жагсаалтын дагуу олон улсын нэршлийн 141, худалдааны нэршлийн 541 эмийг 30-70 хувиар хөнгөлж, даатгалын гэрээ бүхий 1667 (нийслэлийн 797, орон нутгийн 870) эмийн сангаар дамжуулан даатгуулагчдад олгож байна. Дээрх тогтоол 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 309864 даатгуулагчид 22,2 тэрбум төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлээд байна.

Дөрөв. Монгол Улсын Засгийн Газар Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээний дагуу “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд Ховд аймгийн БОЭТ-ийн барилгыг өргөтгөх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, чадавхи бэхжүүлэх арга хэмжээнүүд төлөвлөгдсөн. Уг төсөл 3 үе шаттайгаар 2020-2029 онуудад хэрэгжих бөгөөд төслийн хүрээнд нийт 11,8 сая долларын (эмнэлгийн барилга байгууламж 10,6 сая доллар, эмнэлгийн тоног төхөөрөмж 1,2 сая доллар, мэдээлэл харилцаа холбооны тоног төхөөрөмж 26,0 мян.доллар) хөрөнгө оруулалт бүхий барилга байгууламжийн дэд бүтцийн ажлыг хийж, тоног төхөөрөмж суурилуулах юм.

Одоогийн байдлаар барилгын өргөтгөлийн зураг төслийн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж, зургийн тендер зарлахад бэлэн болсон. 2022 оноос барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Тав. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр гэхэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтад 18-аас дээш насны хүн ам буюу нийт хүн амын 60 хувийг бүрэн дархлаажуулахаар төлөвлөсөн. Одоогоор 5 төрлийн нийт 3,269,340 тун вакцин (40,000 тун вакциныг Монгол эм импекс ХХК нийлүүлсэн)-ыг татан авч, хүн амыг дархлаажуулж байна. Үүнээс: нийт хүн амын 11.3 хувийг БНЭУ (Серум институтын АстраЗенека вакцин 150,000 тун) болон БНХАУ (Синофарм үйлдвэрийн Вероцелл буюу CorV вакцин 300,000 тун)-аас хандив тусламжаар өгсөн вакцинаар, 20 хувийг КОВАКС хөтөлбөрийн хүрээнд орж ирсэн АстраЗенека (64,800 тун), Пфайзер/БиоНТех (25,740 тун) вакцинаар дархлаажуулж байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас ОХУ-ын Спутник-В “Гам-КОВИД-Вак”

вакцины 20,000 тун, БНХАУ-ын Вероцелл буюу CorV вакцины 2,668,800 тунг худалдан авч хүн амыг дархлаажуулж байна.

Цаашид Монгол Улсын Засгийн газраас 1,332,000 тун БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн Вероцелл буюу CorV вакциныг худалдан авах гэрээ, хэлэлцээрийг хийгээд байна.

Улсын хэмжээнд 5 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар КОВИД-19-ын эсрэг вакцины 1-р тунгийн хамралт 79.5 хувь, 2-р тунгийн хамралт 30.4 хувь тус тус байна. Үүнээс: Улаанбаатар хотын хамрагдвал зохих 953,058 хүнээс 900130 (94.4 хувь) хүн нь эхний тунд, 479,229 (50.3 хувь) хүн нь давтан тунд хамрагдсан. Харин орон нутагт хамрагдвал зохих 1,114,234 хүнээс 742,900 буюу 66.7% нь эхний тунд, 148,850 хүн буюу 13.4% нь давтан тунд хамрагдсан байна.

Хүндэтгэсэн,

САЙД *С. Энхболд* С.ЭНХБОЛД

